

# IPLC ULTIMA

1. Executive Summary . . . . .	3
2. Зах зээлийн задлан шинжлэл . . . . .	3
2.1. Зах зээлийн одоогийн төлөв байдал . . . . .	3
2.2. Криптовалют төлбөрийн хэрэгслийн давуу тал . . . . .	4
2.3. Зах зээлийн хөгжлийн чиг хандлага . . . . .	6
2.4. Ирэх 5 жилийн урьдчилсан таамаглал. . . . .	7
3. PLC Ultima-гийн эрхэм зорилго . . . . .	8
4. PLC Ultima-гийн түүх. . . . .	9
5. Блокчейнд суурилсан PLC Ultima-гийн шийдэл. . . . .	10
5.1. PLC Ultima блокчейн ба төвлөрсөн бус хуваарилалт . . . . .	11
5.2. PLC Ultima зоос нь криптовалютын ямар асуудлыг шийддэг вэ? . . . . .	12
6. PLC Ultima-гийн үнэ цэнийг нэмэгдүүлэх стратеги . . . . .	13
7. PLC Ultima нийгэмлэг . . . . .	14
8. PLC Ultima экосистем . . . . .	14
8.1. Экосистемийн бүтээгдэхүүний тойм . . . . .	15
9. Зах зээлийн сорилтууд . . . . .	17
10. PLC Ultima-гийн хөгжлийн төлөвлөгөө (Road map). . . . .	18
11. PLC Ultima ба аюулгүй байдал . . . . .	19
12. Хариуцлагын мэдэгдэл. . . . .	19

# 1. Executive Summary

Энэ документ нь PLC Ultima баг 2022 оны 3-р улирлын криптовалютын зах зээлийн төлөв байдалд задлан шинжлэл хийж, PLC Ultima-ийн зах зээл дээр гүйцэтгэх үүргийн талаар тайлбарласан. Документээс та төслийн эрхэм зорилго, түүх, үндсэн технологи болон бүтээгдэхүүний тухай мэдээллийг олох болно. Баг нэг гаруй жилийн хугацаанд амжилттай хэрэгжүүлж буй PLC Ultima-гийн үнийг тогтвортой барих стратеги болон ойрын ирээдүйд хийх төслийн төлөвлөгөөний талаар та мэдээлэл авна.

## 2. Зах зээлийн задлан шинжлэл

### 2.1. Зах зээлийн одоогийн төлөв байдал

Криптовалютын зах зээл нь одоо уналтын үед байна гэдэгтэй зах зээлд оролцогчид бүгд санал нийлж байна. Олон мэргэжилтэн активын үнэ буурч, өсөлт удааширсан үеийг илгтэх шинэ “крипто өвөл” ирлээ гэж үзэж байна.

Бараг бусад бүх зах зээлийн адил 2022 онд криптовалюта томоохон уналтад орсон. Гео улс төрийн эрсдэл, эрх баригчдын зүгээс эдийн засгийн өсөлтийг бууруулах, мөн эдийн засгийн уналт үүсэж болзошгүй нөхцөл байдал зэрэг нь активд нөлөөлж байна.

Сөрөг таамаглал, цуу яриа зэрэг FUD (Айдас, тодорхойгүй байдал ба эргэлзээ) ердийн хүчин зүйлс ч мөн үүнд нөлөөлж байна. Жишээ нь: Coinbase бирж дампуурч болзошгүй тухай мэдээнд саяхан зах зээл огцом хариу үйлдэл үзүүлсэн ч удалгүй компаниас үүнийг үгүйсгэсэн.

Оны эхэнд олон хөрөнгө оруулагч гүйлгээгээ хааж, ашиг багатай байсан ч бэлэн мөнгөөр эсвэл хамгийн найдвартай активаар сольж хямрал дуусахыг хүлээхийг илүүд үзсэн. Одоогийн байдлаар Bitcoin болон Ethereum хамгийн дээд утгынхаа ойролцоогоор 70%-ийг алдааад байна. Анхны криптовалюта 2017 оны сүүлийн ханшдаа буцаж ирсэн. 2021 оны 11-р сарын дундуур хамгийн дээд шинэ үнэдээ хүрсний дараа үнэ нь буурч эхэлсэн бөгөөд 2022 оны хавар хурд нь илүү нэмэгдсэн. Дараа нь зах зээлийн оролцогчид өсөлтийн боломжуудыг туршиж үзсэн ч мэдэгдэхүйц “амжилтад” хараахан хүрээгүй л байна.

Үнийн уналтаас гадна салбарт гарсан хамгийн чухал өөрчлөлт нь засгийн газраас хийх крипто зах зээл дээрх зохицуулалт нэмэгдсэнтэй холбоотой. 2021 оны 9-р сард Хятадын Ардын банк дижитал нэгжийг “Хятадын санхүүгийн системд учруулах заналхийлэл” хэмээн тодорхойлж криптовалютаар гүйлгээ

хийхийг хориглосон юм. Хориг нь хэдийн илт байсан Зүүн Азиас дижитал нэгж гаргах урсгалыг хурдасгав: Chainalysis-ийн мэдээлснээр 2019-2020 онд тус бүс нутгаас 50 тэрбум долларын үнэ бүхий криптовалютыг эргүүлэн татсан байна.

АНУ-д криптовалютын эргэлтийг илүү идэвхтэй зохицуулж эхэлсэн юм. Засгийн газрын зүгээс криптовалюутай ажиллах гол чиглэлүүдийг заасан захиргааны тогтоолд ерөнхийлөгч Жо Байден 7-р сард гарын үсэг зурав. Эрх баригчид хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, зах зээлийн ил тод байдлыг хадгалах олон улсын хамтын ажиллагаа, “улсын дижитал валют”-ыг тараахад бэлтгэх, “ирээдүйн мөнгө”-ийг судлахад хүчин чармайлтаа төвлөрүүлэх ёстой. Сангийн яам дижитал активын тухай шинэ хууль тогтоомжийн төлөвлөгөө мөн бэлтгэсэн аж. Гэхдээ үүнийг сайжруулах хэрэгтэй гэдгийг мэргэжилтнүүд [онцолж](#) байна.

Одоогийн байдлаар АНУ-ын бодлого нь криптовалюутай илт дайсагналцах эсвэл эргэлтийг нь хориглох ямар нэг санаа зорилтыг харуулахгүй байгааг тэмдэглүүштэй. Зохицуулалт нь эрх чөлөөг тодорхой хэмжээгээр хязгаарлахыг илтгэнэ гэдэг нь илт байна. Хэдий тийм ч одоогоор АНУ-ын эрх баригчдын үйл ажиллагаа нь зах зээлийг нухацтай хязгаарлах хүсэл гэхээсээ илүү хөрөнгө оруулагчдадаа үнэнч байгааг харуулж байна.

Энэ нь тодорхой нэг хэмжээгээр зах зээлийн байдлыг бүхэлд нь харуулж байна. Шинэ сорилтоос үл хамаарч криптовалют нь үндсэн давуу тал, хурдацтай өсөх боломжоо хадгалсаар байна.

## 2.2. Криптовалют төлбөрийн хэрэгслийн давуу тал

Дижитал актив нь зүгээр л ирээдүйтэй хөрөнгө оруулалт болохоос гадна хялбар төлбөрийн хэрэгсэл болж байна. Криптовалютыг олон төрлийн байгууллага, компани хүлээж авдаг. Үйлчилгээнийхээ төлбөрт криптовалют авдаг хувиараа бизнес эрхлэгч олох нь бүр ч хялбар болсон.

Үүнээс гадна 2021 онд биткоиныг анх удаа улсын хэмжээнд хууль ёсны төлбөрийн хэрэгсэл болгож зөвшөөрсөн юм. Үүнийг одоо Сальвадорт мөнгөн тэмдэгт болгон ашиглаж байна. Үүнтэй төстэй шинэчлэлт хийх талаар бусад улсад ч мөн хэлэлцэж байна.

Криптовалютаар төлбөр хийхийн гол давуу талууд нь:

- бие даасан байдал,
- хөрөнгийн баталгаатай хяналт,
- хэзээ ч, хэнд ч хамаагүй төлбөр төлөх,

- нэрийн бүрэн нууцлал,
- хямд үнэ.

Криптовалютын зохицуулалтын гол даалгавруудын нэг нь мөнгө угаахтай тэмцэх юм.

Чанд хатуу дүрэм байхгүй бол гэмт хэрэгтэн, луйварчдын хувьд криптовалюта нь ашигтай хэрэгсэл болж хувирна гэдгийг зохицуулагчид ихэвчлэн онцолдог.

Зохицуулалтын гол эсэргүүцэгчид энэ нь криптовалютаын гол давуу талуудын нэг болох гүйлгээний эрх чөлөөг хязгаарлаж болзошгүй хэмээн эмээж буйгаа илэрхийлсэн юм.

Дадлагаас харахад эдгээр айдас нь үндэслэлгүй юм. Tornado Cash холигчийг хаасан явдал нь үүний жишээ болж болно: АНУ-ын эрх баригчдын хоригийг үл харгалзан платформ [үргэлжлүүлэн](#) ажилласаар байна.

Гэхдээ шинэ хуулийн хүрээнд ч криптовалютаын гүйлгээ нь голчлон чөлөөтэй, төвлөрсөн бус хуваарилалттай хэвээр үлдэж байна. Тэгээд ч криптовалютаын технологийн үндсийг өөрчлөх нь тийм хялбар биш юм.

Дижитал актив эзэмшигчид үүнийг ямар ч хязгаарлалтгүйгээр дэлхийн хаанаас ч хамаагүй дурын хэтэвч рүү шилжүүлэх боломжтой. Хэн ч гүйлгээг зогсоох эсвэл царцаах боломжгүй, хэн ч таныг албадан төлбөрийн зорилгоо тайлбарлахад эсвэл тайланд зориулж албадан бичиг баримт бүрдүүлэхэд хүргэж чадахгүй.

Биржийн бус хэтэвч, тэр дундаа “хүйтэн” гэж нэрлэгддэг хэтэвчийг блоклох боломжгүй бөгөөд доторх мөнгө нь зөвхөн хэтэвчний эзнийх болно.

Криптовалютыг дурын үед хэнд ч хамаагүй илгээк боломжтой. Биткоиноор төлбөр хийхийн тулд банк эсвэл зохицуулагчийн зөвшөөрөл авах шаардлагагүй. Танд зөвхөн хүлээн авагчийн хэтэвчний хаяг л хэрэгтэй.

Криптовалют нь буяны болон олон нийтийн байгууллага, мөн хүн бүрд санхүүгийн үйлчилгээ хүртээмжтэй байдаггүй бүс нутагт бизнесийн ажиллагааг хялбарчилдаг. Жишээ нь: одоог хүртэл банкны үйлчилгээ өргөн тархаагүй байгаа Африкт криптовалюта нь фиат төлбөрийг амжилттай орлох боломжтой юм. Түүнээс гадна Куб улсын хувьд дижитал актив нь хөрөнгийн хөдөлгөөнийг хязгаарласан улсуудтай хийх худалдааг эртнээс хөнгөвчилсөн байна.

Криптовалютыг төлбөрийн хэрэгсэл болгон дөнгөж ашиглаж эхэлж буй хүмүүс дижитал активын гүйлгээг хянах боломжгүй гэсэн олон нийтийн дунд дэлгэрсэн үнэмшил нь үндэслэлгүй гэдгийг анхаарах хэрэгтэй. Үүнийг хийхэд тийм хялбар биш ч энэ нь боломжтой: гүйлгээний үндсэн мэдээллийг бүртгэдэг бөгөөд хандалтын тохиргоо нь олон нийтийнх байдаг, тодорхой нөхцөлд сүлжээн дэх тодорхой хаяг болон түүний эзэмшигчийн хооронд холболт үүсгэж болно.

Гэхдээ криптовалютын хэрэглэгч дижитал активаа уламжлалт санхүүгийн системтэй холбодоггүй, жишээлбэл банкны дансаа ашиглан бирж дээрх дансаа цэнэглэдэггүй эсвэл биржээс карт руу мөнгө гаргадаггүй бол нэрийг нь олж илрүүлэх бараг боломжгүй юм.

Эцэст нь хэлэхэд криптовалютаар төлбөр хийхэд уламжлалт аргаас хамаагүй хямд байдаг. Энэ тохиолдолд татвар ногдуулахгүй бөгөөд төлбөрийн системийн үйлчилгээний төлбөр шаардахгүй. Олборлогчдын ажлын зардал нь фиат төлбөрийн зардлаас хамаагүй бага, ялангуяа олон улсын шилжүүлгийн хувьд их бага байдаг.

Америкийн бизнес эрхлэгч, BitMEX биржийн үүсгэн байгуулагч Артур Хэйс криптовалютыг их тогтворгүй байдлын үед хамгийн сайн хөрөнгө гэж [үзэж байна](#). Засгийн газар хөрөнгийн чөлөөт хөдөлгөөнийг эрс хязгаарлах ирээдүйн хамгийн гутранги хувилбарт ч криптовалют нь төлбөрийн болон хадгаламжийн бие даасан хэрэгсэл хэвээр үлдэх юм. Криптовалютыг “фиат” мөнгө шиг хязгаарлаж, хураан авч, хянаж болохгүй.

Таны дижитал актив хэзээ ч таных байхаа болихгүй.

## 2.3. Зах зээлийн хөгжлийн чиг хандлага

Энэ “крипто өвөл” нь өмнөхүүдээсээ нэлээд олон хүчин зүйлээр ялгаатай гэдгийг мартаж болохгүй. Хамгийн чухал нь хөрөнгө оруулалтын байгууллагуудын эрс нэмэгдсэн үүрэг юм. Жилийн өмнө гэхэд л эдгээр байгууллага нь 70 тэрбум долларын Bitcoin эзэмшиж байв. Хөрөнгө оруулалтын томоохон сангуудаас гадна Tesla, MicroStrategy зэрэг корпорацууд криптовалют худалдаж авсан.

Хөрөнгө оруулалтын олон байгууллага одоо ч гэсэн дижитал активыг сонирхсоор байна. Tesla худалдаж авсан Bitcoin-оо зараагүй, активаа одоо ч хадгалсаар байгаа гэж Илон Маск онцолсон. Шинэ буллран буюу зах зээл дээрх хөрөнгө оруулагчдын дийлэнх нь криптовалют худалдаж авах шинэ үе эхлэхэд хөрөнгө оруулалтын байгууллагууд оролцох хангалттай их нөөцтэй. Харин тэдний нэр хүнд нь болгоомжтой тоглогчдын криптовалют сонирхох сонирхлыг дэмждэг. Энэ удаад активаа түүхэн дээд цэгтээ хүргэх оролцогч нь зөвхөн хувийн трейдерүүдээр зогсохгүй.

Криптовалютын ерөнхий тархалт нь бас чухал үүрэг гүйцэтгэнэ. Сүүлийн хэдэн жилийн хугацаанд дижитал актив нь илүү олон хүнд танигдаж, хүртээмжтэй болсон. 2022 оны эхэнд 106 сая хүн зөвхөн биткоин эзэмшиж байв.

Криптовалютын зах зээл нь тогтмол тэлж шинэ хөрөнгө оруулагчдын анхаарлыг татдаг. Энэ нь шинэ өсөлтийн үндэс болдог. Эцэст нь техникийн

чухал шинэчлэлт нь томоохон үүрэг гүйцэтгэдэг. Биткоины сүлжээг шинэ халвинг буюу зоос шинэ үүсгэх хурд тогтмол буурч, олборлолтын урамшууллыг багасгах явц хүлээж байна. Халвинг нь систем дэх тэнцвэрийг сэргээж анхны криптовалютын үнэд эерэгээр нөлөөлдөг гэж үздэг. Сүүлийн халвинг нь 2020 оны 5-р сард болсон бөгөөд үүний дараа нь зах зээл хурдан өсөж эхэлсэн. Дараагийн халвингийг 2024 онд хийхээр төлөвлөсөн байна.

Өөр нэг чухал үйл явдал нь Ethereum сүлжээний Proof-of-Stake протоколд шилжих шилжилт юм. Шилжилтийг урт хугацааны турш төлөвлөсөн бөгөөд эцэст нь нэг ойрын ирээдүйд хэрэгжүүлнэ. Шинэчлэлт нь сүлжээний олон асуудлыг шийдэж Ethereum-ийн хэрэглэдэг эрчим хүчний хэмжээг бууруулах ёстой. Дэлхий даяар цахилгаан эрчим хүчний үнэ огцом өсөж буй нөхцөл байдалд энэ нь маш чухал юм.

Эрх баригчдын зүгээс хэрэгжүүлэх зах зээлийн шинэ зохицуулалтын тухай үнэлгээ таамаглал ихээхэн ялгаатай байна. Бүрэн чөлөөт зах зээлийг дэмжигчид хуульд сэтгэл хангалуун биш байгаа бөгөөд бие даасан байдлаа хадгалж үлдэхийг хүсэж байна. Хэдий тийм ч олон хөрөнгө оруулагч болон шинжээч зохицуулалт нь криптовалютад тус болно гэж үзэж байна.

Тоглоомын шинэ дүрэм нь зах зээлийг илүү ил тод, тогтвортой болгоно. Энэ нь эргээд өсөлтийн “түлш” болж болох шинэ хөрөнгийг татах юм.

## 2.4. Ирэх 5 жилийн урьдчилсан таамаглал

Криптовалютын зах зээлийн 5 жилийн динамикийг нарийвчлан таамаглах боломжгүй. Дижитал активт гадны олон хүчин зүйл нөлөөлдөг бөгөөд ихэнх нь дурын үед өөрчлөгдөж болзошгүй. Гэсэн хэдий ч өөдрөг байх шалтгаан бас бий.

Тогтмол эргэлздэг хүмүүс үүссэн зах зээлийн нөхцөл байдалд криптовалютын сул дорой байдлын шинж тэмдгийг харж байгаа тул дижитал активаас одоогоор зайлсхийх хэрэгтэй гэж үзэж байна. Гэвч бусад шинжээч үүнд шинэ “удаан” хугацаанд эзлэх байр суурь нээж, одоо байгаа байр сууриа бэхжүүлэх сайхан боломж гэж үздэг.

Ийм хямд үнээр криптовалюта худалдаж авах боломж ойрын ирээдүйд гарахгүй гэж итгэл дүүрэн хэлж болно.

Edelman Financial Services амжилттай санхүүгийн компанийг үүсгэн байгуулагч, криптовалюта сонирхогч Рик Эдельман криптовалютад “та бидний сүүлийн 35 жилийн турш харж байгаагүй баялаг бүтээх боломж”-ийг харж байна. Тэрээр дижитал активын ямар ч тохиолдолд хурдацтай өсөх асар их боломжоор энэ үнэлгээгээ тайлбарлаж байна.

Сүүлийн залруулгын гол шалтгааныг тэрээр зөвхөн гадны хүчин зүйлд биш, мөн зах зээл дээрх “хөшүүргэтэй” арилжаанд зориулсан хэт их зээлтэй холбоотой гэж үзэж байна. Үнийн огцом уналт нь их хэмжээний алдагдалд хүргэсэн ч зах зээлийг “цэвэрлэх” боломж олгосон юм. Эдельман үүссэн нөхцөл байдлыг араас нь бараг бүх активын өсөлт ажиглагдсан 2008 оны хямралтай харьцуулж байна.

Түүний бодлоор одоогийн крипто өвөл дахиад хэдэн сар үргэлжилж болох ч дараа нь хурдан сэргэж, шинэ дээд цэг үүсэх аж. Биткойны үнэ ойрын ирээдүйд 100 000\$-т хүрч магадгүй гэж тэр үзэж байна.

Ирэх таван жилд криптовалют хувийн хөрөнгө оруулагчид болон хөрөнгө оруулалтын байгууллагуудын портфолиогийн чухал бөгөөд өргөн тархсан нэг хэсэг болж байр сууриа бататгана гэдэгт Эдельман итгэлтэй байна.

Бусад шинжээч, юуны түрүүнд уламжлалт санхүүгийн системийн төлөөлөгчид зах зээлд илүү консерватив үнэлгээг өгдөг. Тэдний бодлоор 2023 онд дижитал актив өмнөх дээд цэгтэй ойртох аж. Тэдний бодлоор Тэр үед биткойны үнэ ойролцоогоор 50 000\$-ын түвшинд байна гэж тэд үзэж байна. 2025 он гэхэд дижитал актив шинэ түвшинд гарах буюу биткойны үнэ 100 000\$-т хүрнэ.

Мэргэжилтнүүд криптовалютын динамикийн үндэс нь мөчлөг гэж онцолж байна. Энэ талаараа дижитал активын зах зээл нь үнэт цаасны зах зээлтэй төстэй, тэнд өсөлт бүрийг уналт, харин уналт бүрийг өсөлт дагадаг.

Криптовалют нь нэгээс олон удаа үнийн уналтыг даван гарч, өмнөх дээд цэгтэй эргэн ирж, дараа нь шинийг тогтоодог байсан. Тиймээс дижитал актив нь хөрөнгө оруулагчдын хувьд, ялангуяа урт хугацааны хөрөнгө оруулалтын хувьд сонирхол татсан хэвээр байна.

### **3. PLC Ultima-гийн эрхэм зорилго**

PLC Ultima нь онлайн төлбөрийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор блокчейн технологийг ашиглан бүтээсэн криптовалют юм. PLCU-гийн зорилго бол хүссэн хүн бүр криптовалютыг хялбархан ашиглаж, юу ч, хаанаас ч хамаагүй PLCU ашиглан худалдаж авах, мөн ухаалаг утсан дээрээ PLCU зоосыг бие даан олборлох боломжийг олгох юм.

Хэрэглэгч нь зоосныхоо цорын ганц эзэмшигч нь байна. Тэрээр чөлөөтэй зоос олборлох, үрэх, шилжүүлэх, хадгалах, өвлүүлэх, мөн бусад гүйлгээг хямд, хурдан, аюулгүй хийх боломжтой.

PLCU криптосистемд шинэ технологи хөгжүүлж, нэвтрүүлсний ачаар биткойн болон бусад зоосны концепцод байдаг цоорхой, алдаа дутагдлыг



тооцож үзэн, засаж залруулсан болно. Үүний хажуугаар бид зах зээл дээр одоо байгаа бусад зоостой өрсөлддөггүй, харин өөрсдийн гэсэн зах зээлийг үүсгэж, хэдийн одооноос тэргүүлэгчийн байр суурийг эзлээд байна.

PLC Ultima нь криптовалютын төлбөрийн зах зээл дээр, тэр дундаа нийтийн хэрэглээний төлбөрийн хэрэгслийн салбарт тэргүүлэгчдийн нэг болоход үнэхээр тэмүүлж байна. PLCU зоосыг анхнаасаа өдөр тутмын хэрэглээний төлбөрийн хэрэгсэл болгон ашиглахад аль болох тохиромжтой байхаар бүтээсэн. Зах зээлийн зарим оролцогч биткоиноор бараа, үйлчилгээний төлбөр хийх боломжийг санал болгодог ч уг валютыг төлбөр төлөх бодит арга биш, харин маркетингийн хэрэгсэл болгон ашигладаг. Биткоин ашиглан хийсэн нийт гүйлгээний 90 гаруй хувь нь зах зээл дээрх арилжааны үнийн зөрөөн дээр ажиллах арилжааны хүрээнд байдаг.

Үүний хажуугаар PLC Ultima нь фиат валют руу шилжих цэг болохыг төлөвлөж байна. Гүйлгээ хийх богино хугацаа, тогтворгүй байдлын эрсдэл бага байх болно. PLCU криптовалют нь дэлхийн хаанаас ч хамаагүй зуучлагчгүйгээр хийх шуурхай гүйлгээ, бодит цагийн горимд 24 цаг ажиллах ажиллагаа, системийн аюулгүй байдал ба хамгаалалт, бие даасан байдал, нэрийн бүрэн нууцлал, PLCU-г фиат мөнгө болон бусад зоос болгох чөлөөт хөрвүүлэлтийг илтгэнэ. Дебит карт, АТМ зэрэг төлбөрийн цогц механизм нь үйлчлүүлэгч болон худалдаачин нарт тохиромжтой өргөн хэмжээний төлбөрийн хэрэгсэл болох болно.

## 4. PLC Ultima-гийн түүх

PLC Ultima нь 2016 онд Швейцар улсан байгуулагдсан инновац гарааны бизнес юм.

Крипто бүтээгдэхүүн дээр ажилласан олон жилийн туршлагатай хөгжүүлэгчдийн баг уг төслийг бүтээсэн.

Өнөөдрийн хувьд PLC Ultima нь Швейцар, Герман, Австри, АНЭУ, Хонгконг зэрэг улсад байрлах групп компани юм. Эдгээрийн улс бүр нь тогтвортой байдал, аюулгүй байдал, хөгжингүй эрх зүйн тогтолцоо, инновацид нээлттэй байдал, ирээдүйд чиглэсэн үр дүнтэй глобал шийдлийг хэрэгжүүлдгээрээ алдартай.

Зах зээл дээр одоо байгаа асуудлуудыг шийдвэрлэх блокчейн үүсгэх санаа анх 2016 онд хөгжүүлэгчдэд ирж байсан бол 2017 он гэхэд биеллээ олсон байна. 2018 онд дефляцийн coinbase гүйлгээнд суурилсан өвөрмөц блокчейнийг эхлүүлсэн.

PLC Ultima бол 2016 онд Швейцарьт байгуулагдсан шинэлэг стартап юм.

Төслийг крипто бүтээгдэхүүн дээр ажиллаж байсан олон жилийн туршлагатай хөгжүүлэгчдийн баг бүтээсэн.

Өнөөдөр PLC Ultima нь Швейцарь, Герман, Австри, АНЭУ, Хонг Конг зэрэг улсын компаниудын нэгдэл юм. Эдгээр улс бүр тогтвортой байдал, аюулгүй байдал, хөгжингүй хууль эрх зүйн тогтолцоо, инновацид нээлттэй байдал, ирээдүйд чиглэсэн дэлхийн үр дүнтэй шийдлүүдийг хэрэгжүүлдгээрээ алдартай.

PLC Ultima-г үүсгэн байгуулагч Рейнхардт Алекс нь блокчейн шинээр санаачлагчдын нэг болсон юм. Рейнхардт Алекс нь цуврал бизнес эрхлэгч, венчур хөрөнгө оруулагч, бизнесийн хөгжлийн мэргэжилтэн болно.

Тэрээр Берлин хотын Гумбольдтын нэрэмжит их сургуулийн эдийн засгийн факультетийг төгссөн. Гарааны бизнес, венчур хөрөнгө оруулалтын салбарт 10 гаруй жил ажилласан туршлагатай. 1,5 жилийн хугацаанд тэрээр хэдэн арван сая долларын эргэлттэй хэд хэдэн бизнес болон өнөөдөр дэлхий даяарх нэг сая хагас гаруй хүнийг нэгтгэсэн олон улсын нийгэмлэгийг үүсгэн байгуулсан.

Томоохон хэвлэл The Entrepreneur крипто салбарын хамгийн нөлөө бүхий 10 хүний жагсаалтдаа Алексийг [оруулсан](#) байна. The Entrepreneur нь 1979 оноос хойш хэвлэгдэж буй дэлхийн хамгийн алдартай бөгөөд нөлөөлөлтэй бизнесийн хэвлэлүүдийн нэг юм. The Entrepreneur хэвлэл нь маркетинг, бизнес, бизнес эрхлэлт, борлуулалт ба санхүүгийн тухай бичдэг. Сар бүр сэтгүүлийн сайтаар бараг 15 сая хүн зочилдог нь Forbes, Inc., Bloomberg зэрэг хэвлэл мэдээллийн салбарын аваргуудтай харьцуулагдахуйц юм.

## 5. Блокчейнд суурилсан PLC Ultima-гийн шийдэл

PLC Ultima блокчейн нь Litecoin блокчейн дээр суурилдаг. Хоёр блокчейн нь хоёулаа сүлжээний тогтвортой байдал, ил тод байдал болон Segregated Witness протоколын шинэчлэлтийг ашиглах боломжтой гүйлгээ боловсруулах өндөр хурдаараа онцлог.

**Сүлжээний үндсэн параметрууд:**

**Max Supply: 11 000 000 PLCU**

**Консенсуст хүрэх арга: нарийвчлан тогтоосон нарийн төвөгтэй ажлын гүйцэтгэлийн баталгаа (2016 блок тутамд нарийн төвөгтэй байдлыг дахин тооцоолно)**

**Блокийн хэмжээ: 4 Мб**

**Давтамж: 1 блок кажде 1,5 минуты**

**Хэш функц: CryptoNight алгоритм**

PLC Ultima-гийн хөгжүүлэгчид Litecoin блокчейний функцийг өргөжүүлж хэрэглээний хамрах хүрээг нь тэлсэн. PLC Ultima блокчейн нь CryptoNight хэшлэх алгоритмыг ашигладаг. Баг нь ухаалаг гэрээгээр тодотгосон минтингийн тусламжтайгаар оролцогчдын дунд урамшуулал хуваарилах илүү шударга хуваарилалтыг нэвтрүүлсэн. Үүнээс гадна тус шийдлийг сүлжээг хуваах, хакердах оролдлого, блокчейнийг өөрчилж хуулбарлах, түлхүүрийн орон зайд халдах зэрэг бүх төрлийн халдлагад өртөмтгий эсэхийг нь туршиж шалгасан.

Litecoin дээр суурилсан Ultima PLC блокчейний экосистем нь гүйлгээг дуусгахад олборлолт хийх шаардлагатайг харуулж байна. Гэхдээ PLC Ultima-гийн хөгжүүлэгчид уламжлалт олборлолт нь үр ашиггүй, харин олборлолтын салбар нь крипто эдийн засгийн капиталжуулалтын уналтаас хамгийн их хохирсныг анзаарсан. Дээр нь нэмээд олборлолтын тоног төхөөрөмж нь бүтэн улс хэрэглэх хэмжээний цахилгаан эрчим хүч хэрэглэдэг тул дэлхийн байгаль орчинд муугаар нөлөөлдөг.

Хэрэглэгчид заавал олборлолтод их хэмжээний цахилгаан эрчим хүч зарцуулж, олборлолтын тоног төхөөрөмж худалдан авах албагүй. Мөн хөгжүүлэлтийн баг хэрэглэгчдэд зориулж ямар нэг сугалаагүйгээр шагнал авах баталгаа олгодог сүлжээгээр минтинг хийх боломжийг нэмсэн.

## **5.1. PLC Ultima блокчейн ба төвлөрсөн бус хуваарилалт**

Төвлөрсөн бус хуваарилалт нь блокчейний гол давуу талуудын нэг юм. PLC Ultima багийн үзэж байгаачлан төвлөрсөн бус хуваарилалт нь бизнес, хувь хүн, боловсролын байгууллага, засгийн газар, ашгийн бус байгууллага зэрэгт блокчейний технологийг үр дүнтэй нэвтрүүлэхэд шийдвэрлэх хүчин зүйл болдог аж.

Уламжлалт санхүүгийн хувьд систем нь бүрэн төвлөрсөн, харин үйлчлүүлэгчид нь хувийн мэдээлэл, актив зэрэг өөрийн активыг хянах эрхийг банкуудад олгодог. Биткоин болон бусад криптовалюта нь төвлөрсөн байгууламж шаардахгүйгээр мөнгө гаргах, хадгалах төвлөрсөн бус хуваарилалтай, ил тод өөр сонголтыг санал болгосон. Төвлөрсөн бус хуваарилалтай систем нь зөвшөөрөлгүйгээр эзэмших боломжийг олгодог тул хэн ч хүссэнээрээ, бодсоноороо платформыг ашиглах, үүсгэх боломжтой байдаг. Консенсуст тулгуурлан шийдвэр гаргадаг: гүйлгээг нэг зангилаан дээр биш, харин бүлэг зангилаагаар баталгаажуулдаг.

Сүлжээний оролцогчид гүйлгээний талаар шийдвэр гаргаж, кодыг өөрчлөхөд санал өгч, сүлжээг хөгжүүлэхэд оролцдог. Ингэснээр тодорхой гүйлгээг баталгаажуулахын тулд бүх зангилааны 51-ээс дээш хувь нь энэ гүйлгээг жинхэнэ гэж хүлээн зөвшөөрсөн байх шаардлагатай.

Энэ нь блокчейний өөр нэг чухал давуу тал болох бие биенээ мэдэхгүй эсвэл итгэдэггүй талуудын хооронд итгэлцэл олж авах боломжийг олгодог. Блокчейний төвлөрсөн бус хуваарилалт нь зоос эзэмшигчид нэг хүн эсвэл хэсэг бүлэг хүн мөнгийг нь захиран зарцуулах шийдвэр гаргах эрхгүй гэсэн баталгаа болдог. Ингэснээр

төвлөрсөн нэг байгууллагад эрсдэлийг үүрүүлэхгүй, үүний хажуугаар өөр хүнд итгэх шаардлага гарахгүй.

## **5.2. PLC Ultima зоос нь криптовалютын ямар асуудлыг шийддэг вэ?**

Асуудал: гүйлгээний хурд удаан байх нь олон криптовалютын хувьд гардаг асуудал

Шийдэл: PLC Ultima блокчейнийг Litecoin блокчейн дээр тулгуурлан үүсгэсэн тул гүйлгээ боловсруулах өндөр хурдтай байдаг.

Асуудал: тогтворгүй ханш

Шийдэл: нарийвчлалтай тусгай өсөлтийн стратегийн ачаар PLCU нь зах зээл уналттай үед ч тогтвортой хэвээр үлддэг. Өсөлтийн стратегид валютын ханшийг бэхжүүлэх цогц арга хэмжээ багтдаг: зоос тогтмол шатаах, дефляцийн механизм, нийгэмлэгийн тогтмол өсөлт, PLCU зоосыг хий болгож ашиглах.

Асуудал: ихэнх криптовалют нь техникийн мэдлэггүй хэрэглэгчдийн хувьд хэцүү

Шийдэл: PLCU хэрэглэгчдийн талаас илүү хувь нь криптовалютын зах зээл дээрх шинэхэн хэрэглэгчид байдаг. PLCU багийн нэг зорилго бол аппуудыг аль болох энгийн бөгөөд ашиглахад хялбар болгох юм. Ашиглахад хялбар интерфэйсээс гадна хэрэглэгчид бүтээгдэхүүнтэй ажиллах хамгийн дэлгэрэнгүй зааварчилгааг авдаг. Нэмээд PLC Ultima тусламжийн алба нь амралтын өдөргүйгээр 5 хэлээр шуурхай тусламж үзүүлэхээр ажилладаг.

## 6. PLC Ultima-гийн үнэ цэнийг нэмэгдүүлэх стратеги

Төсөл бүтээх санааны үе шатанд PLC Ultima баг зоосыг тогтмол өсгөх стратегийг бодож олсон. Уг стратеги нь зах зээл уналттай үед ч хөрвөх чадвар, тогтвортой ханшийг хадгалах боломжийг олгодог.

Стратегид дөрвөн чиглэл багтдаг:

### 1. Зоос шатаах

Зоос тогтмол шатаах явцын ачаар зах зээл дээр боломжтой PLCU зоосны тоо тогтмол буурч байдаг.

### 2. Дефляцийн механизм ашиглах

Зорилготой их хэмжээний зоос шатаахаас гадна сүлжээнд гүйлгээ хийх явцад шимтгэлийг тогтмол шатаадаг. Шатаах зоосны хэмжээ нь 1-3% байдаг. Энэ нь зоосны дефляци шинж чанарыг дэмждэг.

PLCU-гийн санал эхэндээ хязгаарлагдмал байсныг тэмдэглэвэл зохино. Энэ нь зах зээл дээр инфляци үүсэх боломжийг арилгаж, PLCU зоосыг жинхэнэ дефляцийн криптовалюта болгодог. Ийм криптовалюта нь ханшийн хэлбэлзэлд илүү тэсвэртэй байдаг.

### 3. Томоохон дэд бүтэц

Ихэвчлэн арилжаанаас ашиг олоход зориулж үүсгэсэн зах зээл дээрх ихэнх криптовалютаас ялгаатай нь PLC Ultima зоос нь орчин үеийн бүтээгдэхүүнүүд багтдаг томоохон дэд бүтэцтэй бөгөөд заримынх нь хувьд одоогоор зах зээл дээр ижил төстэй бүтээгдэхүүн байхгүй байна. Энэ баримт бичгийн 8-р заалтаас төслийн дэд бүтцийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг авч болно.

### 4. Нийгэмлэгийн ачаар өсөх их боломж

Томоохон бөгөөд хөгжингүй экосистемийн логик үр дагавар нь нийгэмлэгийн тогтмол өсөлт юм. Ингээд одоогийн байдлаар PLC Ultima-гийн бүтээгдэхүүнийг дэлхийн 120 гаруй улсад 1,6 сая гаруй хүн хэрэглэж байгаа бөгөөд сар бүр энэ тоо хэдэн мянгаар нэмэгдсээр байна. PLC Ultima нийгэмлэг болон түүнийг хөгжүүлэх хэрэгслүүдийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг энэ баримт бичгийн 7-р заалтад тайлбарлах болно.

## 7. PLC Ultima нийгэмлэг

PLC Ultima нийгэмлэг нь экосистемийн зоосны үнийг өсгөх хүчирхэг хүчин зүйл, төслийн өрсөлдөөнт чадварын давуу тал. Төслийг эхлүүлсэн мөчөөсөө л эхлэн баг нийгэмлэгийн хөгжлийг үндсэн зорилтуудынхаа нэг гэж зарласаар ирсэн.

Одоогийн байдлаар экосистемийн бүтээгдэхүүний хэрэглэгчийн тоо нь 1,6 саяаас давж байгаа бөгөөд хэрэглэгч тус бүр дэлхийн крипто сонирхогчдын нийгэмлэгт нэгдэж, дэлхийн крипто зах зээл дээр экосистемийг сурталчлах хүчирхэг суваг болж байна.

PLC Ultima нийгэмлэгийн гишүүд PLCU дэд бүтцийн төслүүдийг (маркетплейс, краудфандингийн платформ гэх мэт) ашиглан арилжаа хийж, валютын ханшийн өсөлтөөс орлого олдог. Бүх үйлдэлд PLCU зоос шаардагдах тул нийгэмлэгийн идэвхтэй байдал нь үндсэн зоосны өсөлтөд шууд нөлөөлдөг. Зоосоор хийсэн гүйлгээ бүр нь зоосны эрэлтийг нэмэгдүүлж, зах зээл дээрх нийлүүлэлтийг бууруулах тул эдгээр хүчин зүйлийн нэгдэл нь PLCU экосистемийн үндсэн зоосонд эерэгээр нөлөөлдөг.

Өнөөдрийн байдлаар PLC Ultima крипто нийгэмлэг нь зах зээл дээрх хамгийн том, олон соёлт нийгэмлэгүүдийн нэг болоод байна. Латин Америкаас Герман хүртэл уулзалт, сургалтын арга хэмжээ зохиодог нь өдөр бүр хүчирхэг, нийгэмлэгийг бүрдүүлэх боломжийг олгодог! PLC Ultima багийн нийгэмлэгээ хөгжүүлэх ийм арга барил нь криптовалютын ертөнцөд ховор байдаг бөгөөд төслийн өсөлтийн гол хөдөлгөгч хүчний нэг юм.

## 8. PLC Ultima экосистем

PLC Ultima нь зөвхөн нийгэмлэг биш, мөн бүтээгдэхүүний томоохон экосистем юм. Криптовалютын эриний эхэнд криптовалютын дэд бүтцэд тавих шаардлагын жагсаалт тийм ч урт биш байв: зоос олборлох, хадгалах, худалдаж авах, худалдаалах боломж байхад л хангалттай байсан буюу энэ нь үнэндээ арилжаанаас ашиг олдог хэрэгсэл гэсэн нэр хүндийг криптовалютад авчирсан юм.

Галзуу крипто зах зээлийн цаг үе түүхнээ бүдгэрэн үлдэж буй өнөө үед хамгийн амжилттай зоос нь зөвхөн криптовалют олборлох, хадгалах, худалдаалахаас гадна худалдан авалтын төлбөр төлөх, краудфандингийн төслийг дэмжих, хувийн бизнесээ байгуулахад ашиглах боломжийг олгодог дэд бүтцийн бүтээгдэхүүний дотор ажилладаг зоос болж байна.

Ийнхүү гол давуу тал нь тогтвортой байдал, цаашдын хөгжлийн өргөн боломж бололцооны хослол гэж тооцогддог нарийн төвөгтэй бөгөөд хувийн зохион

байгуулалттай орчин болох криптовалютын экосистем үүсдэг. Өнөөдөр ийм экосистемд, жишээ нь, ердийн крипто биржийн хүрээнээс хэдийн хэтэрсэн Ethereum экосистем эсвэл Binance Smart Chain тооцогдож болно.

Эдгээр экосистемийн нэгд нь цогц, олон түвшинт дэд бүтцээр урт хугацааны тогтвортой хөгжлийг хангадаг PLC Ultima мөн орно. Криптовалют хэрэглэгчдийн тоог тасралтгүй нэмэгдүүлж, бодит амьдрал дээрх өдөр тутмын хэрэгцээндээ зоос ашиглах боломжтой болгохын тулд PLC Ultima баг зөвхөн өөрийн гэсэн бүрэн төвлөрсөн бус хуваарилалттай блокчейн зохиогоод зогсохгүй, мөн өндөр технологийн бүтээгдэхүүний цогц багцыг бүтээсэн болно.

Өнөөдөр PLC Ultima экосистемд Ultima Farm болон Ultima Wallet аппууд, Platin Hero шинэлэг краудфандингийн платформ, PlatinDeal олон улсын маркетплейс, PlatinSale хувийн зарлалын платформ, PLC крипто дебит карт болон өөр бусад олон зүйл багтаж байна.

## 8.1. Экосистемийн бүтээгдэхүүний тойм

### PLC Debit Card

PLC Debit Card нь экосистемийн гол бүтээгдэхүүнүүдийн нэг юм. Энэ нь дэлхийн бараг аль ч улсад криптовалютаар худалдан авалтын төлбөрөө хийх боломжийг олгодог крипто дебит карт юм. Уг карт нь Litecoin, Bitcoin, Bitcoin Cash, Ethereum, USDT, EOS, BAT ба PLCU гэх томоохон долоон криптовалютыг дэмждэг. Дансны таван валют боломжтой: евро, доллар, фунт, хятад юань, япон иен. Картын дансны хязгаар нь 5 сая евро, гүйлгээний шимтгэл нь 1-2% байдаг.

### Platin Passport

Platin Passport нь хоёр хүчин зүйлт баталгаажуулалтын өгөгдөл, баталгаажуулалт гэх мэт хэрэглэгчийн тухай бүх мэдээллийг агуулдаг. Platin Passport нь Platin Hero, PlatinDeal зэрэг экосистемийн бүх бүтээгдэхүүнд хандах нэгдсэн төв юм.

Аль нэг бүтээгдэхүүнд бүртгүүлсний дараа систем нь хэрэглэгчид зориулж бүх бүтээгдэхүүнд хандах нэг бүртгэл автоматаар үүсгэнэ. Жишээлбэл, та PlatinDeal-д бүртгүүлсэн бол Platin Passport нь танд зөвхөн платформыг ашиглахад хялбар болгохоос гадна Platin Hero-д хандах эрх олгоно.

### Ultima Wallet

Ultima Wallet нь PLCU зоос хадгалах, зоосоор гүйлгээ хийхэд зориулсан олон үйлдэлт хэтэвч юм.

Гар утасны энэ апп нь PLCUX блокчейн дээр шинэ хэтэвч үүсгэдэг. Ultima Wallet-д шинэ хэтэвч үүсгэснээр хувийн болон олон нийтийн түлхүүрийг зөвхөн та ганцаарчлан эзэмших тул гуравдагч этгээд таны хэтэвч дэх зоосонд хандах боломжгүй болох юм.

Ultima Wallet-ын функцийг хамгийн өргөн хүрээний гэж зоригтойгоор хэлж болно.

Хэтэвч дээрээс зоосоор гүйлгээ илгээх, хүлээн авахад хялбар, хурдан бөгөөд аюулгүй. Та гэр бүл, найз нөхдөдөө зоос илгээх эсвэл зоосоор бараа, үйлчилгээний төлбөрөө төлж болно.

Минтинг дууссаны дараа та фермээс зоосоо хэтэвч рүү гаргах боломжтой.

Ultima Wallet апп нь экосистемийн янз бүрийн үйлчилгээнд ухаалаг гэрээ байгуулах боломжийг олгодог. Онлайн дэлгүүрт хялбархан нэгтгэдэг PlatinPay төлбөрийн системээр дамжуулан бараа, үйлчилгээний төлбөрийг төлөх хөтөлбөрт хэтэвч бас оролцдог. Ultima Wallet аппыг ашиглан та гүйлгээ болон царцаасан зоосныхоо тоог мөн хянах боломжтой.

Ultima Wallet аппыг App Store эсвэл Google Play дээрээс үнэгүй татан авч болно.

Хэтэвчний аюулгүй байдлын асуудлыг баг чухалчлан авч үзсэн. Хувийн түлхүүрийг б оронтой ПИН кодоор шифрлэсэн найдвартай (бөгөөд стандарт бус) шифрлэлт, шифрлэсэн өгөгдлийг төхөөрөмж дээр (iOS-д зориулсан Secure Storage-д) хадгалах хадгалалт нь төхөөрөмж алдагдсан эсвэл хулгайлагдсан тохиолдолд ПИН кодыг тааж олох, хэтэвч рүү зөвшөөрөлгүй хандахад маш хэцүү болгодог.

Хувийн түлхүүр нь зөвхөн ухаалаг гар утсан дээр хадгалагддаг бөгөөд зөвхөн ирж буй гүйлгээнд гарын үсэг зурах мөчид ашиглагддаг буюу сүлжээгээр хэзээ ч дамжуулагддаггүй. Түлхүүртэй бүх үйлдлийг зөвхөн ухаалаг гар утсан дээр гүйцэтгэдэг тул гүйлгээ хийхэд гадны сервер оролцуулахаар тусгаагүй.

## **PlatinDeal**

PlatinDeal нь ямар ч бараа, үйлчилгээг худалдан авах, худалдаалж болох глобал маркетплейс юм. Одоогоор PlatinDeal 2.0 хувилбарыг хөгжүүлж байна: тодорхой хугацаанд зоос царцаасныхаа төлөө IKEA-гаас эхлээд Apple, тансаг зэрэглэлийн автомашины дилер хүртэл дэлхийн ямар ч хамаагүй дэлгүүрийн гэрчилгээг бараг үнэгүй авах боломжтой талбар. PlatinDeal нь худалдан авалтын салбарт жинхэнэ нээлт болно, ерөнхийдөө та бараа, бүтээгдэхүүний төлбөрийг төлөх шаардлага бараг гарахгүй юм!



## Platin Hero

Platin Hero краудфандингийн платформ нь win-win зарчмаар ажилладаг: төсөл нь хөрөнгө санхүүжилт, санаагаа сурталчлан дэвшүүлэх боломжийг, харин хэрэглэгчид нь сонирхсон төслүүдийг нь дэмжих боломжийг авна

## Ultima Cashback сайт

Ultima Cashback нь бэлэн мөнгөний буцаан олголтын хөтөлбөрт оролцох сайт юм. Сайт дээр бэлэн мөнгөний буцаан олголтын хөтөлбөр сонгох, хөтөлбөрийн хүрээнд авсан бэлэн мөнгөний гүйлгээг хянах болон бусад олон зүйлийг хийж болно.

## PlatinSale

PlatinSale нь PLCU зоосоор ямар ч бараа, үйлчилгээг худалдаж авах, худалдах боломжтой глобал маркетплейс юм. Уг платформ нь нийгэмлэгийн хэлээр буюу англи, герман, орос, испани хэлээр ажилладаг. PlatinSale нь PLC Ultima нийгэмлэгийн аливаа гишүүнд дэвшилтэт худалдаачин болох боломжийг олгодог: хялбар онлайн дэлгүүр үүсгэх бүх хэрэгсэл платформ дээр бий. PlatinSale дээр худалдан авагч болохын тулд платформ дээр бүртгүүлэх ч шаардлагагүй.

## 9. Зах зээлийн сорилтууд

Криптовалютын зах зээлд гарсныхаа дараа төслүүд нь хэдэн улсад хууль эрх зүйн зохицуулалт байхгүй, хакерын өндөр идэвхтэй байдал, олон нийтийн зүгээс криптовалютад үл итгэх байдал, хэт өндөр хэлбэлзэл зэрэг олон асуудал бэрхшээлтэй тулгардаг.

PLC Ultima баг энэ бүх асуудлыг амжилттай даван туулсаар ирсэн. Ийнхүү дэлхийн өнцөг булан бүрийн хуульчдын баг төслийн ажиллагаа явуулдаг улсуудын хууль тогтоомжийг сайтар нарийвчлан судалдаг. Болзошгүй халдлагад бүтээгдэхүүний тэсвэртэй байх чадварыг сайжруулахаар хөгжүүлэгчдийн баг тогтмол ажилладаг бол PLC Ultima баг нь хувийн өгөгдөл ба хэтэвчээ хамгаалахад зориулсан урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай хэрэглэгчдэд идэвхтэй мэдээлдэг. Уналттай зах зээлийн үед ханшийг барихын тулд дефляцийн стратегийг хэрэгжүүлдэг бөгөөд энэ талаар бид энэ баримт бичгийн 6-р зүйлд дэлгэрэнгүй тайлбарласан. Үүнээс гадна PLC Ultima маркетингийн баг нь сургалтын материал бэлтгэх, онлайн болон офлайн арга хэмжээ зохион байгуулах зэргээр криптовалютын тухай олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхээр ажиллаж байна.

## 10. PLC Ultima-гийн хөгжлийн төлөвлөгөө (Road map)

PLC Ultima баг нь одоогийн болон ирэх жилийн төлөвлөгөөгөө ил тод зарладаг.

2022 оны 4-р улирлын төлөвлөгөөнд багтсан:

- Краудфандингийн платформыг бүрэн эхлүүлэх (платформ одоогоор туршилтын горимд ажиллаж байна).
- Бэлэн мөнгөний буцаан олголтын хөтөлбөрийг идэвхтэй түгээх.
- Шинэ биржүүдийн жагсаалтад багтах.

Binance криптовалютын биржид нэвтрэх нь 2023 оны гол даалгавар юм. Одоогоор PLC Ultima зоосыг арав гаруй томоохон крипто бирж дээр арилжаалж байна.

HitBTC <https://hitbtc.com/plcu-to-usdt>

AAX <https://trade.aax.com/en-US/spot/PLCU:USDT>

Coinsbit [https://coinsbit.io/ru/trade\\_classic/PLCU\\_USDT](https://coinsbit.io/ru/trade_classic/PLCU_USDT)

DigiFinex <https://www.digifinex.com/en-ww/trade/USDT/PLCU>

Hotbit [https://www.hotbit.io/exchange?symbol=PLCU\\_USDT](https://www.hotbit.io/exchange?symbol=PLCU_USDT)

Azbit [https://azbit.com/exchange/PLCU\\_USDT](https://azbit.com/exchange/PLCU_USDT)

XT.com [https://www.xt.com/trade/plcu\\_usdt](https://www.xt.com/trade/plcu_usdt)

QMall [https://qmall.io/trade\\_classic/PLCU\\_USDT](https://qmall.io/trade_classic/PLCU_USDT)

Coinsbit India [https://coinsbit.in/trade/PLCU\\_USDT](https://coinsbit.in/trade/PLCU_USDT)

Biconomy [https://www.biconomy.com/exchange?coin=PLCU\\_USDT](https://www.biconomy.com/exchange?coin=PLCU_USDT)

BigONE <https://www.big.one/en/trade/PLCU-USDT>

CoinW <https://www.coinw.com/front/fastTrading?symbol=945>

BitMart [https://www.bitmart.com/trade/en?layout=basic&symbol=PLCU\\_USDT](https://www.bitmart.com/trade/en?layout=basic&symbol=PLCU_USDT)

MEXX [https://www.mexc.com/ru-RU/exchange/PLCU\\_USDT](https://www.mexc.com/ru-RU/exchange/PLCU_USDT)

Gate.io [https://www.gate.io/ru/trade/PLCU\\_USDT](https://www.gate.io/ru/trade/PLCU_USDT)

FMFW.io <https://fmfw.io/ru/plcu-to-usdt>

EXMO [https://exmo.com/trade/PLCU\\_USDT](https://exmo.com/trade/PLCU_USDT)

## 11. PLC Ultima ба аюулгүй байдал

Хуваарилалттай ямар ч системийн аюулгүй байдал нь туйлын төвөгтэй бөгөөд цогц ажил юм. PLC Ultima нь үүний шийдэлд маш хариуцлагатай хандсан болно. Өнөөгийн крипто ертөнцөд урьд өмнө нь хэзээ ч байгаагүй аюулгүй байдлыг хангахын тулд багийн хийсэн гол алхмуудыг доор танилцуулав:

- Найдвартай бөгөөд шалгагдсан блокчейн. Крипто ертөнцийн өнөөгийн нөхцөл байдалд системчлэгдсэн, иж бүрэн задлан шинжлэл хийсний дараа PLC Ultima-гийн үндэс болгож "хуучин цаг"-ийн төлөөлөгч Litecoin-ы хамгийн сүүлийн үеийн батлагдсан, тогтвортой хувилбарыг сонгосон болно. Энэ нь сүлжээний тогтвортой байдал, халдлагад тэсвэртэй (Time Wrap, 51% халдлагаас хамгаалагдсан, хардфорк байхгүй) инновацийг (Segregated Witness, Atomic Transactions гэх мэт) амжилттай хослуулсан Bitcoin-ы илүү уян хатан, хурдан, аюулгүй, тогтмол хувьсан өөрчлөгддөг залгамжлагч юм.
- Хеш функц. PLC Ultima-гийн хеш функцээр CryptoNight алгоритм сонгогдсон. Энэ нь нэг талаасаа олборлолт, халдлагад одоо байгаа гуравдагч талын программ хангамжийг ашиглах боломжгүй болгох бол нөгөө талаасаа блокийг найдвартай хамгаалж, олборлолтын тусгай тоног төхөөрөмжийг ашиглах боломжгүй болгодог.
- Гар утсан дээрх найдвартай шифрлэлт. Зургаан оронтой ПИН код болон гар утсан дээрх хэтэвчний шифрлэлтийн өөрчилсөн алгоритм нь одоо байгаа хакердах хэрэгслийг ашиглах боломжгүй, ерөнхийдөө хэтэвчний түлхүүрийг сонгоход маш хэцүү болгодог. Ухаалаг гар утсан дээрх хурууны хээ болон Face ID ашиглан нэвтрэх сонголт нь нэмэлт аюулгүй байдлыг хангадаг.

## 12. Хариуцлагын мэдэгдэл

Задлан шинжлэлийн энэ тайланд задлан тусгасан мэдээллийг бүрэн гүйцэд гэж тооцож болохгүй бөгөөд гэрээний харилцааны ямар нэг элемент агуулаагүй болно. Задлан шинжлэлийн энэ тайлангийн агуулга нь компанийн талуудын хувьд заавал биелүүлэх ёстой зүйл биш бөгөөд шинэчилсэн бодлогын баримт бичгийг вебсайтад байршуулах замаар компани нь задлан шинжлэлийн энэ тайлангийн зарим нэг хэсгийг зоос худалдаалахаас өмнө, үеэр болон дараа нь дурын шалтгаанаар өөрчлөх, засах, нэмэх эсвэл хасах эрхтэй.

Задлан шинжлэлийн энэ тайлан нь компанийн өмч бөгөөд үүнийг засаж бичих, хуулах, гуравдагч талд шилжүүлэх эсвэл бусад ямар нэг хэлбэрээр тараахыг хориглоно. Энэхүү бодлогын баримт бичгийг зөвхөн хөндсөн нарийн асуудлуудтай холбоотой тодорхой үзэл баримтлалд хандах гарын авлага хэлбэрээр ерөнхий мэдээлэл өгөхөд зориулсан болно.

Задлан шинжлэлийн энэ тайлан нь хөрөнгө оруулалт, хууль эрх зүй, татвар, норматив дүрэм, санхүү, нягтлан бодох бүртгэлийн зөвлөгөө биш бөгөөд зоос худалдан авах гүйлгээг үнэлэх дурын явцад цорын ганц үндэслэл болох ёсгүй. Боломжит худалдан авагч зоос худалдаж авахаасаа өмнө уг гүйлгээний боломжит ашиг, үүрэг хариуцлага болон бусад үр дагаврыг тодорхойлохын тулд хууль эрх зүй, хөрөнгө оруулалт, татвар, нягтлан бодох бүртгэл болон бусад зөвлөхтэй зөвлөлдөх ёстой.

Задлан шинжлэлийн энэ тайлангийн аль ч зүйлийг ямар нэг танилцуулга, хөрөнгө оруулалт хийх урилга гэж үзэж болохгүй, мөн аль ч хууль эрх зүйн хүрээнд ямар нэг үнэт цаас худалдаж авах санал эсвэл хийх хүсэлтэд хамаарахгүй. Дижитал зоосоор эсвэл түүнийг ашиглан гүйлгээ хийхийг хориглосон эсвэл ямар нэг байдлаар хязгаарладаг аливаа хууль эрх зүйн харьяаллын хууль тогтоомж эсвэл норматив дүрэм журмын шаардлагыг тооцолгүйгээр энэ баримт бичгийг бүтээсэн бөгөөд тэдгээрт захирагдахгүй.

Зоос нь дижитал валют, үнэт цаас, бараа эсвэл бусад санхүүгийн хэрэгсэл биш бөгөөд 1933 оны Үнэт цаасны тухай хууль, Америкийн Нэгдсэн Улсын аливаа муж улсын үнэт цаасны тухай хууль эсвэл оршин суугч нь зоосны боломжит эзэмшигч болох аливаа хууль эрх зүйн харьяаллын үнэт цаасны тухай хууль зэрэг өөр улсын үнэт цаасны тухай хууль тогтоомжийн дагуу бүртгэгдээгүй болно.

Байнгын оршин суудаг хаяг, байршил эсвэл бүртгэл нь нь Америкийн Нэгдсэн Улс (муж улсууд болон Колумбийн тойргийг оруулна), Пуэрто-Рико, Америкийн Нэгдсэн Улсын Виржиний арлууд, Америкийн Нэгдсэн Улсын эзэмшлийн бусад газар эсвэл дижитал зоосоор гүйлгээ хийхийг холбогдох хууль эсвэл бусад норматив актаар хориглосон эсвэл ямар нэг байдлаар хязгаарласан улс эсвэл нутаг дэвсгэр болох иргэн, хувь хүн, хуулийн этгээдэд зоосыг санал болгож эсвэл тарааж болохгүй, мөн дамжин зарах эсвэл эзэмшигч нь өөр аргаар захиран зарцуулах эрхээ шилжүүлэхийг хориглоно. Хэрэв эдгээр хязгаарлалтад багтах хүн зоос худалдаж авсан бол үүнийг хууль бус, зөвшөөрөлгүй, хууран мэхлэх маягаар хийсэнд тооцогдож, үүнийхээ төлөө улсынхаа хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх болно.

Тус компани нь Сингапур, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Өмнөд Солонгос эсвэл дижитал зоостой холбоотой эсвэл ашиглаж хийсэн гүйлгээ нь хязгаарлалтын дүрэм журамд захирагддаг эсвэл компаниас бүртгүүлэх эсвэл холбогдох аливаа төрийн байгууллагаас тусгай зөвшөөрөл авахыг шаарддаг бусад улс, нутаг дэвсгэрт зоос санал болгодоггүй, түгээдэггүй, мөн ямар нэг зохицуулалттай үйл ажиллагааны хүрээнд бизнес (үйл ажиллагаа) явуулдаггүй.

Зоос худалдан авч буй хүн бүрд түүнийг харьяа улсынх нь хууль тогтоомжийн дагуу энэ баримт бичгийг хууль ёсны үндэслэлтэйгээр анхааралд нь хандуулах боломжтой хүн мөн гэдэгт үндэслэн задлан шинжлэлийн энэ тайланг өөрт нь ирүүлсэн болохыг сануулъя.

Зоосны боломжит худалдан авагч бүр тухайн хууль эрх зүйн харьяаллын хүрээнд байхдаа хууль ёсоор зоос худалдан авч, дараа нь өөрийн улсын хууль эрх зүйн харьяалалд байрлах өөр худалдан авагчид дахин зарах боломжтой эсэхийг тодорхойлохдоо хариуцлага хүлээнэ.

Задлан шинжлэлийн энэ тайланд агуулагдах олон тооны тайлан, үнэлгээ, санхүүгийн мэдээлэл нь таамаглалын мэдэгдэл эсвэл мэдээлэл юм. Таамаглалын ийм мэдэгдэл эсвэл мэдээлэл нь бодит үйл явдал эсвэл үр дүн нь таамаглалын ийм мэдэгдэл эсвэл мэдээллээр илтгэсэн эсвэл илэрхийлсэн үнэлгээ эсвэл үр дүнгээс ихээхэн ялгаатай байх болно гэсэн ойлголтод хүргэж болзошгүй мэдэгдэж буй болон үл мэдэгдэх эрсдэл, тодорхойгүй байдалтай холбоотой.

Компани нь уг документод заасан болон холбогдох хууль тогтоомжийн дагуу зоос худалдан авахад шаардлагатай шалгуурыг хангаагүй хэн бүхэнд криптосистемд хандах эрх олгохоос татгалзах эрхтэй. Тэр дундаа, компани нь сонголтынхоо дагуу хүссэн үедээ тогтоох зохих байдлын шалгуурыг хангаагүй хүмүүст хандах эрх олгохоос татгалзаж болно.

Англи хэл дээрх задлан шинжлэлийн энэ тайлан нь төслийн тухай мэдээллийн албан ёсны үндсэн эх сурвалж болно. Энэ баримт бичигт агуулагдсан мэдээллийг үе үе бусад хэл рүү орчуулж болно. Ийм орчуулгын явцад энэ баримт бичигт агуулагдах зарим мэдээлэл алдагдсан эсвэл гажуудсан байж болзошгүй. Ийм ялгаатай зурвасын нарийвчлалыг баталгаажуулах боломжгүй. Эдгээр орчуулга болон англи хэл дээрх задлан шинжлэлийн энэ тайлан хоёрын хооронд ямар нэг зөрчил эсвэл зөрөө гарсан тохиолдолд англи хэл дээрх энэхүү баримт бичгийн заалт нь давуу эрхтэй байна.